



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2016 оны 4 дүгээр сар


Ерөнхий тойм: Оны эхний 4 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 11.1%-иар буюу 276.4 сая ам.доллараар буурч 2210.1 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 7.2%-иар буюу 104.9 сая ам.доллараар, импорт 16.6%-иар буюу 171.5 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлжээ. Тайлант хугацаанд экспортын дүн импортын дүнгээс 484.6 сая ам.доллараар давж гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 66.6 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 4 сараар			Өөрчлөлт			
	2013	2014	2015	2014/2013		2015/2014		2014	2015	2016	2015/2014		2016/2015	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	10,627	11,011	8,467	384	3.6%	(2,545)	-23.1%	2,959	2,487	2,210	(472)	-16.0%	(276)	-11.1%
Экспорт	4,269	5,775	4,669	1,506	35.3%	(1,105)	-19.1%	1,432	1,452	1,347	20	14%	(105)	-7.2%
Импорт	6,358	5,237	3,797	(1,121)	-17.6%	(1,439)	-27.5%	1,526	1,034	863	(492)	-32.2%	(172)	-16.6%
Тэнцэл	(2,089)	538	872	2,627		334	62.2%	(94)	418	485	512		67	15.9%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид нөлөөлдөг суурь үзүүлэлтүүдийн нэг юм. 2010 оноос хойш тогтмол алдагдалтай байсан валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2014 оны сүүлийн хагасаас ашигтай гарч эхэлсэн. Уг үзүүлэлт 2016 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр 497.1 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 42.9 сая ам.доллараар буурсан байна.

Дүрслэл 1. Валютын төлбөртэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




Дүрслэл 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 62.4% буюу 1379.0 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 10.4% буюу 228.8 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 10.8%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 27.8%-иар тус тус буурсан байна.

Дүрслэл 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Хүснэгт 2. Худалдааны нөхцөлийн индекс /2012 оны 12 сар суурьтай/

Үнийн индексийн төрөл*	2015.4 сар	2016.3 сар	2016.4 сар	Жил Δ	Сар Δ
Экспорт	0.97	0.68	0.74	-24%	8%
Зэсийн баяжмал	0.46	0.33	0.35	-24%	6%
Чулуу нүүрс	0.59	0.38	0.41	-31%	9%
Ямааны угаасан ноолуур	0.42	0.32	0.34	-20%	5%
Импорт	0.59	0.54	0.56	-5%	3%
Хэрэглээний бараа	0.74	0.76	0.77	5%	1%
Хөрөнгө оруулалтын бараа	0.50	0.48	0.51	2%	6%
Нефтийн бүтээгдэхүүн	0.60	0.40	0.43	-28%	9%
Худалдааны нөхцөл	1.65	1.26	1.32	-20%	5%

* Индексийн өөрчлөлтөд голлох хувь нэмэр оруулсан бараагаар задлав.

Гадаад худалдааны нөхцөлийн индекс тайлант хугацааны эцэст өмнөх оны мөн үеэс 19.8%-иар буурч, өмнөх сараас 4.6%-иар өсч 1.321-д хүрлээ. Тайлант сард голлох импортын үнэ өссөн хэдий ч зэсийн баяжмал, чулуун нүүрсний экспортын үнэ өссөн нь худалдааны нөхцөл өмнөх сараас сайжрахад нөлөөлжээ.

Экспортын гадаад худалдаа 2016 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 7.2%-иар буюу 104.9 сая ам.доллараар буурсан. Экспортын бууралтыг ерөнхий ангиллаар задалвал аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын өсөлт нь нийт экспортыг 1%-иар өсөхөд нөлөөлсөн ч, уул уурхайн түүхий эдийн экспортын бууралт нь нийт экспортыг 8%-иар буурахад нөлөөлжээ. Улмаар уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 2 нэгж хувиар буурсан бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний жин 2 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Экспортын гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2014			2015			2016			Δ (2015/2014)			Δ (2016/2015)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%2	Дүн	Өсөлт	%2
1. Уул уурхай		1,284	90%	1,294	89%	1,179	88%	10	1%	1%	(115)	-9%	-8%		
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	316	530	37%	415	667	46%	558	637	47%	138	26%	10%	(30)	-4%	-2%
1.2. Чулуун нүүрс	5,354	273	19%	4,248	194	13%	5,008	155	12%	(78)	-29%	-5%	(39)	-20%	-3%
1.3. Боловсруулаагүй нефть	2,095	207	14%	2,518	123	8%	2,876	99	7%	(84)	-40%	-6%	(24)	-20%	-2%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	1,584	126	9%	1,500	81	6%	1,380	45	3%	(45)	-36%	-3%	(37)	-45%	-3%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	2,172	90	6%	3,362	133	9%	4,304	168	12%	43	48%	3%	35	26%	2%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	27	27	2%	43	53	4%	38	39	3%	26	95%	2%	(13)	-25%	-1%
1.7. Жонш, лейцит, нефелинт	83	18	1%	81	19	1%	74	17	1%	1	4%	0%	(2)	-11%	0%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	1	10	1%	2	13	1%	2	8	1%	3	28%	0%	(5)	-38%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	0	3	0%	0	3	0%	0	2	0%	(0)	-8%	0%	(0)	-15%	0%
1.10. Мөнгө /тонн/	0	-	0%	27	7	1%	20	8	1%	7	1%	0%	0	6%	0%
1.11. Бусад	10	1	0%	6	0	0%	39	1	0%	(1)	-85%	0%	1	0%	0%
2. Мал аж, ахуй		101	7%	71	5%	74	5%	(30)	-30%	-2%	3	4%	0%		
2.1. Амьд мал, малын мах	1	1	0%	2	4	0%	2	4	0%	3	249%	0%	0	4%	0%
2.2. Арьс, шир	172	21	1%	132	15	1%	79	14	1%	(6)	-28%	0%	(1)	-6%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	4	0%	0	3	0%	0	2	0%	(1)	-28%	0%	(1)	-27%	0%
2.4. Ноолуур	3	71	5%	2	44	3%	2	48	4%	(27)	-38%	-2%	4	8%	0%
2.5. Ноос, бусад үс, хялгас	3	4	0%	3	5	0%	4	6	0%	1	24%	0%	1	12%	0%
2.6. Бусад	0	0	0%	0	0	0%	0	0	0%	0	20%	0%	0	136%	0%
3. Газар тариалан		13	1%	20	1%	10	1%	6	48%	0%	(10)	-50%	-1%		
4. Аж үйлдвэрлэл		33	2%	66	5%	82	6%	34	104%	2%	16	23%	1%		
4.1. Хүнс	0	2	0%	1	11	1%	2	12	1%	9	572%	1%	1	11%	0%
4.2. Ноолууран эдлэл	0	4	0%	0	4	0%	0	2	0%	(0)	-7%	0%	(2)	-39%	0%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	0	2	0%	0	2	0%	0	4	0%	(0)	-14%	0%	2	116%	0%
4.4. Уул уурхай	3	7	1%	11	24	2%	8	22	2%	17	231%	1%	(2)	-8%	0%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	1	0%	0	0	0%	0	0	0%	(1)	-67%	0%	(0)	-17%	0%
4.6. Машиномеханик, тоног төхөөрөмж, эд анги	1	13	1%	0	24	2%	0	40	3%	11	86%	1%	16	68%	1%
4.7. Бусад	85	3	0%	82	2	0%	79	1	0%	(2)	-45%	0%	(0)	-18%	0%
5. Бусад		1	0%	1	0%	0	0%	1	100%	0%	(1)	-64%	0%		
Нийт дүн		1,432		1,452		1,347		20	1%		(105)	-7%			

* 2 - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)

Хүснэгт 4. Экспортын гадаад худалдааны өөрчлөлт, 2016 он

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Уул уурхай	224.7	-195%	(339.7)	295%	(115.0)	-9%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	163.2	-544%	(193.2)	644%	(30.0)	-4%
1.2. Чулуун нүүрс	23.5	-60%	(62.6)	160%	(39.1)	-20%
1.3. Боловсруулаагүй нефть	12.3	-50%	(36.7)	150%	(24.4)	-20%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	(3.9)	11%	(32.9)	89%	(36.7)	-45%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	36.8	106%	(2.1)	-6%	34.7	26%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	(5.0)	37%	(8.5)	63%	(3.5)	-25%
1.7. Жонш, лейцит, нефелинт	(1.5)	74%	(0.5)	26%	(2.0)	-11%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	1.5	-32%	(6.4)	132%	(4.8)	-38%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	(0.2)	57%	(0.2)	43%	(0.4)	-15%
1.10. Мөнгө /тонн/	(2.8)	-653%	3.3	753%	0.4	6%
1.11. Бусад	0.7	98%	0.0	2%	0.8	0%
2. Мал аж, ахуй	1.5	55%	1.3	45%	2.8	4%
2.2. Арьс, шир	(9.4)	979%	8.4	-879%	(1.0)	-6%
2.4. Ноолуур	9.0	247%	(5.4)	-147%	3.7	8%
3. Газар тариалан	(11.6)	118%	1.8	-18%	(9.8)	-50%
4. Аж үйлдвэрлэл	(7.8)	-50%	23.4	150%	15.6	23%
5. Бусад	(0.1)	8%	(0.7)	92%	(0.7)	-64%
Нийт дүн	206.8		(313.9)		(104.9)	-7%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Дүрслэл 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



2016 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр экспортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 206.8 сая ам.доллараар өссөн бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 313.9 сая ам.доллараар буурсан байна.

Бүлэг тус бүрээр авч үзвэл уул уурхайн түүхий эдийн экспортын тоо хэмжээ өссөн хэдий ч үнийн бууралтаас шалтгаалж уг бүлгийн экспорт 8.9%-иар буюу 115.0 сая ам.доллараар буурчээ.

МАА-н түүхий эдийн экспортын үнэ, тоо хэмжээ өссөнөөр уг бүлгийн экспорт 2.8 сая ам.доллараар өссөн бол, рапсын экспортын бууралтаас шалтгаалж газар тариалангийн экспорт 9.8 сая ам.доллараар буурсан байна. Харин машин, тоног төхөөрөмжийн экспортын өсөлтөөс голлон шалтгаалж аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт 23.4%-иар буюу 15.6 сая ам.доллараар өсчээ.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны сарын дундаж үнэ 2016 оны 4-р сард 1,242 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 4%-иар өссөн байна. А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн үнэ тайлант сард харгалзан 4,873, 61 ам.долларт хүрч өмнөх оны мөн үе, өнгөрсөн сартай харьцуулахад зэс 19%-иар, 2%-иар буурсан бол төмрийн хүдэр 16%-иар, 9%-иар тус тус өссөн байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 3 сард 32 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 39%-иар буурч, өмнөх сараас 6% -иар өссөн байна.

Импортын гадаад худалдаа 2016 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 16.6%-иар буюу 171.5 сая ам.доллараар буурсан. Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалвал хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 2%-ийг, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 6%-ийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 9%-ийг тус тус тайлбарлаж байна. Хэрэглээний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 4 нэгж хувиар өссөн бол нефтийн бүтээгдэхүүний жин 7 нэгж хувиар буурчээ.

Хүснэгт 5. Импортын гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2014			2015			2016			Δ (2015/2014)			Δ (2016/2015)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%2	Дүн	Өсөлт	%2
Хэрэглээний бүтээгдэхүүн		427	28%		328	32%		307	36%	(100)	-23%	-7%	(20)	-6%	-2%
Түргэн эдэлгээтэй	254	223	15%	233	188	18%	226	172	20%	(35)	-16%	-2%	(16)	-8%	-2%
Хүнс	111	153	10%	111	128	12%	113	117	14%	(25)	-16%	-2%	(11)	-9%	-1%
Эм, тариа	1	24	2%	1	22	2%	1	25	3%	(2)	-9%	0%	3	12%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	143	45	3%	121	37	4%	111	30	3%	(8)	-18%	-1%	(7)	-20%	-1%
Удаан эдэлгээтэй	38	204	13%	56	140	14%	40	135	16%	(65)	-32%	-4%	(5)	-3%	0%
Гутал, хувиас, цүнх	12	20	1%	12	14	1%	18	15	2%	(6)	-30%	0%	0	2%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба төвөг	8	39	3%	27	33	3%	8	27	3%	(6)	-16%	0%	(6)	-17%	-1%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	0	118	8%	0	76	7%	0	74	9%	(43)	-36%	-3%	(2)	-2%	0%
Бусад удаан эдэлгээтэй бараа	19	27	2%	16	17	2%	14	20	2%	(9)	-35%	-1%	3	15%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн		559	37%		345	33%		278	32%	(214)	-38%	-14%	(67)	-19%	-6%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	9	314	21%	6	198	19%	5	160	19%	(116)	-37%	-8%	(38)	-19%	-4%
Судлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	0	68	4%	0	32	3%	0	29	3%	(36)	-53%	-2%	(3)	-9%	0%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	9	246	16%	5	167	16%	5	131	15%	(79)	-32%	-5%	(35)	-21%	-3%
Барилгын материал	691	184	12%	343	111	11%	158	66	8%	(72)	-38%	-5%	(45)	-40%	-4%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	17	61	4%	12	35	3%	9	51	6%	(27)	-43%	-2%	16	47%	2%
Аж үйлдвэрлэлийн орц		175	11%		155	15%		163	19%	(21)	-12%	-1%	8	5%	1%
Хүнсний орц	25	13	1%	22	10	1%	109	26	3%	(3)	-22%	0%	15	152%	1%
Химийн бүтээгдэхүүн	35	26	2%	43	29	3%	38	24	3%	3	12%	0%	(5)	-17%	0%
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	7	5	0%	7	4	0%	5	5	1%	(0)	-8%	0%	1	14%	0%
Цахилгаан эрчим хүч	0	34	2%	0	42	4%	0	43	5%	9	25%	1%	0	1%	0%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	1	0	0%	0	0	0%	1	1	0%	(0)	-15%	0%	1	457%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтат	263	98	6%	252	69	7%	208	64	7%	(29)	-30%	-2%	(4)	-6%	0%
Нефтийн бүтээгдэхүүн		327	35%		322	20%		243	13%	(150)	-42%	-10%	(91)	-44%	-9%
Дизель түнш	175	185	12%	169	103	10%	107	44	5%	(82)	-44%	-5%	(59)	-57%	-6%
АИ-92, АИ-95	106	117	8%	119	75	7%	103	47	5%	(42)	-36%	-3%	(28)	-37%	-3%
А-80 болон бусад	46	53	3%	35	27	3%	34	23	3%	(26)	-49%	-2%	(4)	-16%	0%
Бусад	0	9	1%	8	2	0%	21	1	0%	(7)	0%	0%	(1)	0%	0%
Нийт дүн		1,526		1,034			863			(492)	-32.2%		(172)	-17%	

%2 - Нийтөсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)

Хүснэгт 6. Импортын гадаад худалдааны өөрчлөлт, 2016 он

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	(8.6)	43%	(11.5)	57%	(20.1)	-6%
Түргэн эдэлгээтэй	(6.6)	42%	(9.0)	58%	(15.6)	-8%
Удаан эдэлгээтэй	(2.1)	46%	(2.4)	54%	(4.5)	-3%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	(90.6)	135%	23.6	-35%	(67.0)	-19%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	(27.5)	72%	(11.0)	28%	(38.5)	-19%
Барилгын материал	(49.2)	110%	4.3	-10%	(44.9)	-40%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	(13.8)	-84%	30.3	184%	16.5	47%
Аж үйлдвэрлэлийн орц	3.9	51%	3.8	49%	7.7	5%
Нефтийн бүтээгдэхүүн	(33.7)	37%	(57.3)	63%	(91.0)	-44%
Дизель түнш	(25.3)	43%	(33.7)	57%	(59.0)	-57%
АИ-92, АИ-95	(7.5)	27%	(20.1)	73%	(27.6)	-37%
А-80 болон бусад	(0.9)	21%	(3.5)	79%	(4.4)	-16%
Бусад	0.6	-55%	(1.8)	155%	(1.2)	0%
Нийт дүн	(128.3)		(43.2)		(172)	-17%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Дүрслэл 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



Тойм тооцооллоос үзэхэд 2016 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр импортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс голлон шалтгаалж нийт дүнгээр 128.3 сая ам.доллараар буурчээ.

Бүлэг тус бүрээр авч үзвэл хэрэглээний бүтээгдэхүүний импортын үнэ, тоо хэмжээ буурснаар уг бүлгийн импорт 6.1%-иар буюу 20.1 сая ам.доллараар буурчээ.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 19.4%-иар буюу 67.0 сая ам.доллараар буурсан нь уг бүлгийн импортын тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалсан.

Харин нефтийн бүтээгдэхүүний импортын тоо хэмжээ болон үнэ зэрэг буурснаар уг бүлгийн импорт 44.4%-иар буюу 91.0 сая ам.доллараар буурчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2013 оноос эхлэн тогтмол буурч байна. Хилийн үнэ 2012 оны 12 сард тонн тутамд 1,270.5 ам.доллар байсан бол 2016 оны 4-р сарын байдлаар тонн тутамд 462.7 ам.долларт хүрээд байна.